

Жилийн үйл ажиллагааны тайлагнал
/маягт 1/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан

Тайлагнах хугацаа	2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Техник импорт ХК, УБГД: 9010001041 ҮЦК: 441 Утасны дугаар: (+976) 70001830,
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	“Монголын Хөрөнгийн Бирж” ХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Гадаад худалдаа
Жилийн эцсийн санхүүгийн тайланда аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Сэргэлт дөл аудит ХХК 2019.08.28.
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	144,675.5
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албантушаалтны нэр	Бэлтгэсэн: Ерөнхий ня-бо С. Дашдулам ТУЗ-ын н.б.д О. Бүжинлхам Хянасан: Гүйцэтгэх захирал Д. Ганцэцэг

1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийнтайлант хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Тайланг хавсаргав.
	Орлогын тайлан	Тайланг хавсаргав.
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Тайланг хавсаргав.

	Мөнгөн гүйлгээний тайлан	Тайланг хавсаргав.
--	--------------------------	--------------------

1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт
	Техник импорт ХК нь санхүүгийн үйл ажиллагаагаа Санхүүгийн тайлагналын олон улсын

дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтөлж бүртгэл тооцоог явуулдаг.

Техник импорт ХК нь 2024 оны жилийн санхүүгийн тайландаа СЗХ-нд бүртгэлтэй, аудит хийх тусгай зөвшөөрөлтэй “Сэрэлт дөл аудит” ХХК-иар аудит хийлгэсэн ба тус аудитын байгууллагын дүгнэлтээр, компанийн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны орлого, үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-д нийцүүлэн Монгол Улсын Сангийн яам, Санхүүгийн зохицуулах Хорооноос гаргасан заавар, журмын дагуу үнэн, зөв илэрхийлэгдсэн байна”-гэж дүгнэгдсэн.

1.2.	Аудитын компанийн дүгнэлтийг хавсаргав.	
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<p>Техник импорт ХК 2024 оны санхүүгийн жилд 203 тэрбум 870,8 сая төгрөгийн борлуулалтын орлого олсон нь өмнөх оноос 24,1 тэрбум төгрөгөөр буюу 13,4 хувиар өссөн.</p> <p>Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 190 тэрбум 584,6 сая төгрөг болж борлуулалтаас олсон ашиг 13 тэрбум 286,2 сая төгрөг болсон нь өмнөх оноос 1 тэрбум 5,5 сая төгрөгөөр буурсан.</p> <p>Үндсэн бус үйл ажиллагааны орлого 987,8 сая төгрөг болж өмнөх оноос 103,3 сая төгрөгөөр өссөн.</p> <p>Гадаад валютын ханишийн алдагдал 4 сая 51,3 мяняган төгрөгт хүрсэн.</p> <p>Ерөнхий ба удирдлагын зардал 4 тэрбум 791,5 сая төгрөг болж өмнөх оноос 399,6 сая төгрөгөөр өссөн, санхүүгийн зардал 5 тэрбум 676,9 сая төгрөг болж өмнөх оноос 819,3 сая төгрөгөөр өссөн.</p> <p>Татвар төлөхийн өмнөх ашиг 3 тэрбум 799,6 сая төгрөг болж өмнөх оноос 1 тэрбум 853,9 сая төгрөгөөр буурсан.</p> <p>Улсын төсөвт ААНОА татварт 379,6 сая төгрөг төлөхөөр тооцож тайлант үсийн цэвэр ашиг 3 тэрбум 419,6 сая төгрөгт хүрсэн.</p> <p>Тайлант хугацаанд компани нь Улсын төсөвт 22,091, 205.6 төгрөг татвар төлсөн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">➤ ААНОА татварт 679,915.2 төгрөг➤ НӨАТ-д 18,524, 378.6 төгрөг➤ Гаалийн татварт 2,176,763.0 төгрөг➤ НДШ-д 451,941.5 төгрөг➤ Бусад татварт 2,206.5 төгрөг <p>Эргэлтийн хөрөнгө оны эцэст 111 тэрбум 533,2 сая төгрөг байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">➤ Мөнгөн хөрөнгө 766,6 сая төгрөг➤ Бараа материал 24 тэрбум 432 сая төгрөг➤ Дансны авлага 69 тэрбум 807,4 сая төгрөг➤ Бусад авлага 16 тэрбум 518,9 сая төгрөг <p>Дансны өглөг 39 тэрбум 222.6 төгрөг болж урьл</p>

		<p>Банкны богино хугацаат зээлийн өглөг 36 тэрбум 992,4 сая төгрөг болж өмнөх оноос 2 тэрбум 195,9 сая төгрөгөөр өсчээ.</p> <p>Эргэлтийн хөрөнгөөр өр төлбөрөө төлөх боломж: $\frac{111 \text{ тэрбум } 533,2 \text{ сая}}{111 \text{ тэрбум } 540 \text{ сая}} = 1,28$ буюу $24 \text{ тэрбум } 540 \text{ сая}$ төгрөг байгаа нь $86 \text{ тэрбум } 992,8 \text{ сая} / \text{өр төлбөр/}$ төлбөрийн чадвар боломжит хэмжээнд байна.</p>
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	<ol style="list-style-type: none"> Цэвэр эргэлтийн хөрөнгө нь $111533,2-86,992,8=75,459.6$ тэрбум төгрөг байгаа нь өмнөх оноос 7,09%-иар өссөн. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа $111533,2-24,432.6 = 1$ $86,992.8$ Эргэлтийн харьцаа нь $111533,2/86,992.8=1,3$ нь эргэлтийн хөрөнгөөрөө өр төлбөр барагдуулах чадвар сайн байгааг харуулж байна.
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	<p>Компани нь үйл ажиллагаагаа хэвийн, тогтвортой явуулахад дотоодын инфляцийн түвшин, гадаад валютын ханш, зах зээл дээр борлуулагдаж байгаа барилгын материалын үнэ /цемент/ импортын бараа бүтээгдэхүүн /мотоцикл, битум/-ийн үнэ чухал нөлөө үзүүлдэг.</p> <p>Тайлант хугацаанд компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлд болон бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд өөрчлөлт ороогүй бөгөөд эхний хагас жилийн байдлаар дотоодын зах зээлд импортын болон дотоодын бараа, материалын үнэ өссөнөөс харилцагч байгууллагуудын худалдан авах чадвар буурсан, бэлэн мөнгөний хомсдол үүссэн, УИХ-ын сонгууль болохтой холбогдуулан улс оронд хэрэгжиж буй бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт саатаж зам, барилгын ажлын явц удааширан, өмнөх жилүүдтэй харьцуулахад барилгын салбарын ажил оройтож эхэлсэн зэрэг үйл явдлууд компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байсан бол сүүлийн хагас жилд ус, цахилгаан болон бараа бүтээгдэхүүний үнэ дахин нэмэгдсэн, гадаад валютын ханш өссөн, бэлэн мөнгөний хомсдол хэвээр үргэлжилсэнээс шалтгаалан эдийн засгийн таагүй байдал нь харилцагч байгууллага, иргэдээс бараа материал худалдан авах, ажил үйлчилгээ үзүүлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж компанийн гол бараа бүтээгдэхүүн болох цемент, арматурын болон бусад бараа материалын борлуулалт буурахад голлох нөлөө үзүүлсэн.</p> <p>Компанийн улиралдагас үүссэн тохиолд байдлаартай</p>

		хэвийн явуулахад шаардлагатай арга хэмжээнүүдийг төлөвлөж, зохион байгуулж хэрэгжүүлэн хяналт тавыж ажиллалаа.
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	<p>Тайлант хугацаанд Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл компанийн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор компанийн Гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн саналын дагуу 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн хурлаараа Худалдаа хөгжлийн банкнаас эргэлтийн хөрөнгийн зориулалтаар 15 тэрбум төгрөгийн зээл авах асуудлыг хэлэлцсэн. Тус хурлаас 15 тэрбум төгрөгийг 12 сарын хугацаатай, жилийн 16%-ийн хүйтэй авч ашиглах, банкны зээлийн барьцаанд зохих журмын дагуу үл хөдлөх хөрөнгө, ирээдүйн орлогоос орж ирэх мөнгөн хөрөнгийг барьцаалуулах эрхийг ТУЗ-ын нийт гишүүдийн 100 хувийн саналаар Гүйцэтгэх удирдлагад олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>Мөн компанийн Төлөөлөн удирдах зөвлөл Гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн саналын дагуу 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн хурлаар Худалдаа, хөгжлийн банкнаас эргэлтийн хөрөнгийн зориулалтаар 15 тэрбум төгрөгийн зээл авах эсэх асуудлыг хэлэлцсэн. Энэхүү хурлаас 15 тэрбум төгрөгийг 24 сарын хугацаатай, жилийн 15,6%-ийн хүйтэй авч ашиглах, банкны зээлийн барьцаанд зохих журмын дагуу үл хөдлөх хөрөнгө барьцаалуулах эрхийг ТУЗ-ын нийт гишүүдийн саналаар Гүйцэтгэх удирдлагад олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>СЗХ-ноос баталсан “Үнэт цаасны журам”-д заасны дагуу уг журамд заасан хугацаанд банкны зээлийн талаар хэлэлцсэн компанийн ТУЗ-ын шийдвэр, тогтоолыг холбогдох нотлох баримтын хамт СЗХ, Монголын хөрөнгийн бирж ХК-д хүргүүлж, биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлж ажилласан.</p>
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зорчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайланг хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх малзэлдлийг тусгана/	

		Банкны богино хугацаат зээлийн оглөг 36 тэрбум 992,4 сая төгрөг болж өмнөх оноос 2 тэрбум 195,9 сая төгрөгөөр өсчээ.
		Эргэлтийн хөрөнгөөр өр төлбөрөө төлөх боломж: <u>111 тэрбум 533,2 сая / Эргэлтийн хөрөнгө</u> = 1,28 буюу <u>24 тэрбум 540 сая</u> төгрөг байгаа нь 86 тэрбум 992,8 сая / өр төлбөр/ төлбөрийн чадвар боломжит хэмжээнд байна.
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	<ol style="list-style-type: none"> Цэвэр эргэлтийн хөрөнгө нь <u>111533,2-86,992,8=75,459.6</u> тэрбум төгрөг байгаа нь өмнөх оноос 7,09%-иар өссөн. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа <u>111533,2-24,432.6 = 1</u> 86,992.8 Эргэлтийн харьцаа нь <u>111533,2/86,992,8=1,3</u> нь эргэлтийн хөрөнгөөрөө өр төлбөр барагдуулах чадвар сайн байгааг харуулж байна.
2.3.	Үнэт цаас гаргагчийн Үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Компани нь үйл ажиллагаагаа хэвийн, тогтвортой явуулахад дотоодын инфляцийн түвшин, гадаад валютын ханш, зах зээл дээр борлуулагдаж байгаа барилгын материалын үнэ /цемент/ импортын бараа бүтээгдэхүүн /мотоцикл, битум/-ийн үнэ чухал нөлөө үзүүлдэг. Тайлант хугацаанд компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлд болон бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд өөрчлөлт ороогүй бөгөөд эхний хагас жилийн байдлаар дотоодын зах зээлд импортын болон дотоодын бараа, материалын үнэ өссөнөөс харилцагч байгууллагуудын худалдан авах чадвар буурсан, бэлэн мөнгөний хомсдол үүссэн, УИХ-ын сонгууль болохтой холбогдуулан улс оронд хэрэгжиж буй бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт саатаж зам, барилгын ажлын явц удааширан, өмнөх жилүүдтэй харьцуулахад барилгын салбарын ажил оройтож эхэлсэн зэрэг үйл явдлууд компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байсан бол сүүлийн хагас жилд ус, цахилгаан болон бараа бүтээгдэхүүний үнэ дахин нэмэгдсэн, гадаад валютын ханш өссөн, бэлэн мөнгөний хомсдол хэвээр үргэлжилсэнээс шалтгаалан эдийн засгийн таагүй байдал нь харилцагч байгууллага, иргэдээс бараа материал худалдан авах, ажил үйлчилгээ үзүүлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж компанийн гол бараа бүтээгдэхүүн болох цемент, арматурын болон бусад бараа материалын борлуулалт буурахад голлох нөлөө үзүүлсэн.

Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй.

Цалин, урамшууллын мэдээлэл

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”, “Цалин, урамшууллын бодлогын журам”-аар олгосон эрх, үргийн хүрээнд 2024 оны ХЭХ-аас баталсан ТУЗ-ын төсөвт заасны дагуу ТУЗ-ын 10 удаагийн хурлын цалинд зориулж ТУЗ-ын 9 гишүүнд 14000000 төгрөгийн цалин олгох, Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан “Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх гэрээ”-ний 1.3-т “Гүйцэтгэх захиралд сар бүр олгох цалингийн хэмжээ нь тогтмол байх ба жилийн эцэст ТУЗ нь компанийн жилийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, санхүүгийн үр ашгийн байдал, эд хөрөнгийн эзэмшил ашиглалт, хамгаалалт, хууль тогтоомжийн хэрэгжилт, ТУЗ-аас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт, Гүйцэтгэх захирлын энэхүү гэрээгээр хүлээсэн бусад ажлын гүйцэтгэлийн үр дүн, дараа оны ажлын бэлтгэл, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан компанийн үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөний биелэлтийг үндэслэн Гүйцэтгэх захирал түүний удирдлагын багт шагнал, урамшуулал олгоно” гэж заасны дагуу гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж, гэрээний биелэлтийг дүгнэж цалин, урамшуулал олгох эсэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

Мөн тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл ТУЗ-ын дэргэдэх Цалин, урамшууллын хорооноос компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”, ТУЗ-ын “Цалин, урамшууллын бодлого”-д заасны дагуу компанийн Гүйцэтгэх удирдлагаас инфляцийн тувшинтэй уялдуулан компанийн нийт ажилтнуудын цалинг 20-30 хувиар нэмэгдүүлэхээр ирүүлсэн саналыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

Техник импорт ХК нь 1958 онд байгуулагдсан, Монгол Улсын импортын ууган компани бөгөөд үйл ажиллагааны чиглэлийн дагуу гадаад, дотоодын олон байгууллагатай хамтран ажилладаг, зам, барилга, тээвэр зууч, өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний худалдаа, хөдөө аж ахуйн салбарт оорийн хувь нэмрээ оруулан ажилладаг, зах зээлд байрь сууриа эзэлсэн, үнэ цэнэтэй харилцагчидтай, үлчлүүлэгчдийнхээ итгэлийг хүлээсэн, мэргэжлийн ур чадвартай, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлсэн, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, 2 дугаар ангилалд багтдаг нээлттэй хувьцаат компани билээ.

Компанийн удирдлагын бүтэц, үйл ажиллагаа

- Хувьцаа эзэмшигчдийн хурал
- Төлөөлөн удирдах зөвлөл
- Гүйцэтгэх удирдлага

Хувьцаа эзэмшигчдийн хурал:

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага юм.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл жил бүр санхүүгийн жил дууссанас хойш 4 сарын дотор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулдаг.

Тайлант хугацаанд компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу амжилттай зохион байгуулж явуулсан.

2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд зориулж Үндэсны төвлөрсөн хадгаламжийн төв ТӨХХК-иас гаргасан “Хувьцаа эзэмшигчдийн судалгаа”-ны дагуу Хувьцаа эзэмшигчдийг бүртгэж, баталгаажуулсан.

Компаниас гаргасан нийт энгийн хувьцааны тоо 1,446,755 ширхэг бөгөөд 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдөр 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөр гаргасан “Хувьцаа эзэмшигчдийн судалгаа”-гаар 461 хувьцаа эзэмшигч компанийн хувьцаа эзэмшигчээр бүртгэгдсэн.

Компанийн нийт энгийн хувьцааны 10 ба түүнээс дээш хувийн энгийн хувьцааг дараах Хувьцаа эзэмшигчид эзэмшдэг. Үүнд:

№	Хувьцаа эзэмшигчдийн нэр	Хувьцааны төрөл	Эзэмшиж буй хувьцааны тоо	Эзэмшиж буй хувь
1.	Д.Ганбат	Энгийн	475 161	32,84%
2.	Д.Ганцэцэг	Энгийн	455 736	31,5%
3.	Г.Содбилэг	Энгийн	480 300	33,2%
4.	Нийт		1 411 197	97,54%

2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд компанийн саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 98,8% нь оролцсоноос гадна ТҮЗ-ын хараат болон хараат бус гишүүд биечлэн оролцож хууль, журамд заасан эрх, үүргээ хэрэгжүүлж ажилласан.

ХЭХ-ын Тооллогын комиссоос компанийн “Дүрэм”-д заасны дагуу нийт хувьцаа эзэмшигчдийн 60%-иас дээш буюу хувьцаа эзэмшигчдийн 98,8% нь оролцсоныг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцож, хурлын ирцийг хурлын даргад илтгэж танилцуулсан.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга ХЭХ-ын дэгийн дагуу хурлын ажиллагааг эхлүүлэх эсэх асуудлаар Хувьцаа эзэмшигчдээс санал авч нийт хувьцаа эзэмшигчдийн саналаар 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эхлүүлж хурлын дэгийн дагуу дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд:

- 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТҮЗ-ын гаргасан дүгнэлт
- 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны тайлан, ногдол ашгийн тайлан
- 2024 оны компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө
- 2023 оны компанийн ТҮЗ-ын үйл ажиллагааны тайлан, 2024 оны ТҮЗ-ын төсөв
- 2024 оны компанийн ТҮЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хурлын дэгийн дагуу компанийн Гүйцэтгэх захирал бөгөөд

1. 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан
2. 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан
3. 2024 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө

ТУЗ-ын нарийн бичгийн дарга О. Бужинлхам

1. 2022 оны ногдол ашгийн тайлан
2. 2023 оны ТУЗ-ын үйл ажиллагааны тайлан, 2024 оны ТУЗ-ын төсөв

ТУЗ-ын гишүүн Г.Уран-Өлзий

1. 2024 оны ТУЗ-ын гишүүнд нэр дэвшигчдийг сонгох асуудлын талаар тус тус танилцуулж хурлын хэлэлцэж буй асуудлаар хувьцаа эзэмшигчдээс тавьсан асуултуудад хариулах, тодруулга хийх үүргээ хэрэгжүүлж ажилласан.

2024 оны ТУЗ-ын гишүүдийг сонгох асуудлаар ТУЗ-ын дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо хуралдаж 2023 оны ТУЗ-ын гишүүдийн ажлын тайлан, хурлын ирцийн бүртгэл, ТУЗ-ын гишүүдийн үйл ажиллагаанд Хороодын дарга нараас өгсөн үнэлгээ, тодорхойлолтыг үндэслэн компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу

2024 оны ТУЗ-ын хараат бус гишүүнээр:

Ж.Баярсайхан

Б.Батсайхан,

Б.Нарантуяа

ТУЗ-ын ердийн гишүүнээр:

Т.Тунгалаг

Д.Баяраа,

Э.Батболд,

Ж.Уртнасан,

С.Бүжинлхам

Г.Уран-Өлзий

нарыг сонгох саналыг гаргаж ХЭХ-д нэр дэвшүүлэхээр шийдвэрлэсэн.

2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын дагуу компанийн Хувьцаа эзэмшигчид ТУЗ-ын Нэр дэвшүүлэх хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэж компанийн засаглалын сургалтанд хамрагдсан гэрчилгээтэй, Компанийн тухай хууль, компанийн Дүрэм, “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д заасан шаардлагуудыг бүрэн хангасан ТУЗ-ын хараат бус гишүүнээр Ж.Баярсайхан, Б.Батсайхан, Б.Нарантуяа нарыг, ТУЗ-ын ердийн гишүүнээр Т.Тунгалаг, Д.Баяраа, Э.Батболд, Ж.Уртнасан, С.Бүжинлхам, Г.Уран-Өлзий нарыг 2024 оны ТУЗ-ын гишүүнээр сонгож баталсан.

Мөн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин, урамшууллын хороог байгуулсан.

ХЭХ-ын Тооллогын комисс хурлаар хэлэлцсэн асуудлаар шийдвэр гаргуулахтай холбогдуулан ТУЗ-ын гишүүдийг сонгох асуудлыг кумулятив аргаар, бусад асуудлыг саналын хуудсаар санал авч нэгтгэн дүгнэж хурлын даргад илтгэж танилцуулсан.

Хуралд оролцсон нийт Хувьцаа эзэмшигчид хурлаар хэлэлцсэн асуудлуудыг бүрэн дэмжиж хурлаас гарах шийдвэр, тогтоолын төслийг 100%-ийн саналаар баталж шийдвэрлэсэн.

2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал, холбогдох баримт материалын хамт холбогдох хууль журамд заасан хугацааны дотор СЗХ, МХБ ХК-д хүргүүлж тайлагнаж ажилласан.

2. Төлөөлөн удирдах зөвлөл

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.

Техник импорт ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн удирдлагыг хэрэгжүүлдэг бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн “Дүрэм” болон “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-аар олгосон эрх, үргийн хүрээнд:

3. Компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах
4. Компанийн Гүйцэтгэх удирдлагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг.

Жил бүр компанийн ТУЗ-ын гишүүдийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас сонгож баталдаг ба ТУЗ-ын даргыг нийт гишүүдийн олонхийн саналаар сонгодог.

2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас компанийн “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-д заасан шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангасан 9 нэр дэвшигчийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгож томилсон ба 9 гишүүний 3 нь хараат бус гишүүнээр, 6 нь ердийн гишүүнээр сонгогдсон.

ТУЗ-ын гишүүдийг хүйсээр ангилвал Төлөөлөн удирдах зөвлөлийн 9 гишүүний 5 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй гишүүнээс бүрдсэн.

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 9 гишүүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулсан бөгөөд ТУЗ-ын нийт гишүүдийн олонхийн саналаар ТУЗ-ын даргаар Т.Тунгалаг сонгогдож ажилласан.

2024 онд Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн тухай хууль, компанийн Дүрэм, “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-д заасны дагуу 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас баталсан тогтоол, шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажилласнаас гадна мөн компанийн санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн.Үүнд:

1. Ногдол ашиг хуваарилах тухай /2024.02.14 №01/
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай /2024.02.26 №02/
3. Банкнаас зээл авах эрх олгох тухай /2024.03.05 №03/
4. Зөвшөөрөл олгох тухай /2024.03.07 №04/
5. Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай /2024.03.19 №05/
6. Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээ /2024.04.18 №06/
7. Банкны зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.05.28 №07/
8. Банкнаас зээл авах эрх олгох тухай /2024.10.14 №08/
9. Банкны зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.12.25 №09/
10. Банкны зээлэнд баталгаа гаргах тухай асуудлаар 9 удаа тус тус хуралдаж 100 хувийн ирцтэй, нийт гишүүдийн 100 хувийн саналаар хурлаар хэлэлцэх асуудлыг шийдвэрлэж тогтоол гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан.

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл компанийн Гүйцэтгэх захиралтай “Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх гэрээ”-г байгуулан тус гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан бөгөөд гэрээний дагуу Гүйцэтгэх удирдлагын ажлын тайланг хэлэлцэж дүгнэсэн.

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Хороод нь “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-д заасны дагуу өөрсдийн эрхлэх чиг үүргийн хүрээнд ТУЗ-ын дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо 2 удаа, Аудитын хороо 6 удаа, Цалин, урамшууллын хороо 3 удаа тус тус хуралдаж үнэлэлт, дүгнэлт гаргаж ажилласан.

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ТУЗ-ын төсвийн дагуу ТУЗ-ын “2024 оны сургалтын төлөвлөгөө”-г баталж ТУЗ-ын гишүүдийг ажил, мэргэжлийнх нь дагуу болон шаардлагатай сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.

ТУЗ-ын “2024 оны сургалтын төлөвлөгөө”-ний дагуу ТУЗ-ын гишүүд болон ТУЗ-ын нарийн бичгийн дарга нарыг гадаад болон дотоодын чиглэлээр 6 удаагийн сургалтанд хамруулахаар төлөвлөсөн бол 2024 оны сургалтын төлөвлөгөөний гүйцэтгэлээр ТУЗ-ын нийт гишүүд 9 удаагийн сургалтанд хамрагдсан.

Тайлант хугацаанд хамрагдсан 11 удаагийн сургалтыг ангилвал:

- 1.ТУЗ-ын гишүүд 9 удаагийн сургалтанд
- 2.ТУЗ-ын нарийн бичгийн дарга 3 удаагийн сургалтанд тус тус хамрагдсан

Тайлант хугацаанд СЗХ, Залуу судлаачдыг дэмжих сан болон ТоС, ОУСК-иас зохион байгуулсан 3 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт ТУЗ-ын нарийн бичгийн дарга хамрагдсан.

ТУЗ-ын дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо ТУЗ-ын нарийн бичгийн даргын хурлын ирцийн бүртгэл болон ТУЗ-ын үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан холбогдох ажлын тайлан, ТУЗ-ын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгсөн ТУЗ-ын дэргэдэх Хороодын дарга нарын тодорхойлолтонд тус тус үндэслэн 2024 оны ТУЗ-ын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч ажилласан ба тус Хорооноос 2024 оны ТУЗ-ын үйл ажиллагааг “Хангалттай сайн” гэж дүгнэсэн.

Мөн тайлант хугацаанд Техник импорт ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн үнэлгээний дагуу гаргаж СЗХ-нд тайлагнаж ажилласан.

Компанийн Төлөөлөн удирдах зовлол СЗХ-ны үнэлгээний тайлангаар өгсөн үүрэг, даалгавар, зөвлөмж, холбогдох хууль, дүрэм журамд заасан шаардлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан.

3. Компанийн Гүйцэтгэх удирдлага

Тайлант хугацаанд компанийн Гүйцэтгэх удирдлага ТУЗ-аас байгуулсан “Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх гэрээ”-нд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажилласан.

Техник импорт ХК-ийн Гүйцэтгэх захирлаар 2006 оноос хойш Дашдондог овогтой Ганцэцэг ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн бүтцэд ямар нэгэн өөрчлөлт ороогүй бөгөөд компанийн бүтэц, зохион байгуулалтын дагуу Гүйцэтгэх удирдлага компанийн дараах нэгж, албадын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, үйл ажиллагааны чиглэлийн дагуу үүрэг даалгавар, зөвлөмж өгч хэрэгжилтэнд хяналт тавьж үнэлэлт дүгнэлт өгч ажилласан.

1. Гүйцэтгэх захирал
2. Дотоод аудитын алба
3. Захиргаа, хүний нөөцийн алба
4. Дэмжих үйлчилгээний алба
5. Инженер техникийн алба
6. Санхүү, бизнесийн алба
7. Бизнес хөгжлийн алба

Тайлант хугацаанд компанийн Гүйцэтгэх удирдлагаас компанийн хэмжээнд 2024 оныг “Компанийн ажил үйлчилгээний чанарыг сайжруулах, ажилтиаа бататгах жил” болгох зорилго тавьж энэ ажлын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж ажилласан. Үүнд:

1. Үйлчлүүлэгч, харилцагч байгууллага, иргэдийн тоог нэмэгдүүлж, харилцагчийн сэтгэл ханамжийг омнохөөсөө нэмэгдүүлэх,
2. ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцооны дүрэм, журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж хэвшихэд нийт ажилтнуудын идэвхи чармайлтыг дээшилүүлэх, бүтээлч чиг хандлагад сургах,
3. Өндөр мэргэжил, мэргэшил бүхий үнэнч шударга хүний нөөцөөр хангагдах,

Тайлант хугацаанд компанийн Гүйцэтгэх удирдлага 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас баталсан шийдвэр, тогтоол, компанийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх, ТУЗ-тай байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүргийн хүрээнд компанийн үйл ажиллагааг догодолгүй, үр ашигтай, хэвийн явуулахтай холбогдуулан дараах ажлуудыг удирдан зохион байгуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Үүнд:

1. Компанийн удирдлага 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас баталсан тогтоол, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2023 оны нэгж хувьцаанд ногдол ашиг хуваарилж

"ҮЦТХТ" ХК-иар зуучлуулан ногдол ашиг тараалгах гэрээ" байгуулж гэрээний дагуу Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ногдол ашгийн мөнгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-д шилжүүлж ногдол ашгийн тайланг холбогдох хууль, журам, СЗХ-ноос ирүүлсэн албан бичигт заасан хугацаанд СЗХ, Хөрөнгийн бирж ХК-д хүргүүлж тайлагнаж ажилласан.

2. Компанийн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хөрөнгө оруулагч, сонирхогч болон оролцогч талуудын хүсэлт, шаардлагад нийцүүлэн ажилласнаар харилцагч хэрэглэгчээ татаж хамрах хүрээ өргөжих, ажил үйлчилгээний хурд, шуурхай байдал, ажлын бүтээмж дээшилж, борлуулалт нэмэгдэх үндэс болсон. Тайлант хугацаанд компани нь 180 гаруй аж ахуйн нэгж, 6,200-гаад эцсийн хэрэглэгчтэй хамтран ажилласан. Тухайлбал мотоцикл, арматур, орон сууц, битум, цемент нийлүүлэх, худалдах чиглэлээр дараах тооны аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллалаа. Үүнд: Мотоцикл 25, Арматур 23, Орон сууц 128, Битум 40, Цемент 85.

Сонирхогч байгууллагуудтай харилцах хүрээнд албан бичиг солилцох, биечлэн уулзах хэлбэрээр хамтран ажиллаж, тэдний санал хүсэлтийг барагдуулж 941 албан тоот илгээж, 290 албан тоот хүлээж авч ажилласан.

Мөн харилцагчийн тоог нэмэгдүүлэх, тэдний сэтгэл ханамжийг дээшлүүлэх, бараа бүтээгдэхүүнээ зах зээлд сурталчлан танилцуулах, бараа бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, ажилтнуудын харилцаа, хандлага, ур чадварыг сайжруулахад онцгой анхаарч төрөл бүрийн мэргэжлийн шаардлагатай сургалтуудыг гадны холбогдох мэргэжлийн байгууллагуудаас авч ажилласан.

3. Компанийн удирдлага компанийн хэмжээнд ISO 9001 чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилтэнд хяналт тавьж сайжруулах арга хэмжээ авч чанаржуулах, үр дүнг хангаж ажиллах чиглэлээр компанийн Дотоод аудитын алба болон алба нэгжийн дарга нарт хугацаатай үүрэг, даалгавар өгч үр дүн, хэрэгжилтийн талаар хариуцсан албадын дарга, холбогдох ажилтнуудаас тайлан авч үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгч удирдлагаар хангаж ажилласан.

4. Компанийн хэмжээнд галын аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор оффисын барилгын галын усны шугам хоолойг стандартын дагуу сэргээн засварлаж хэвийн горимд оруулсны зэрэгцээ галын дүгнэлтийн ээлжит үзлэгт орох ажлыг зохион байгуулж явуулсан. Мөн энэхүү ажлын хүрээнд дүүргийн Онцгой байдлын газраас зохион байгуулагдсан "Гамшиг ослын нэгдсэн сургалт"-нд компанийн ТУЗ-ын гишүүд, компанийн болон охин компаниудын бүх ажилтнууд хамрагдаж сургалтаар гамшиг ослын үед хэрхэн эмнэлгийн тусламж үйлчилгээ, аврах ажиллагaa үзүүлэх, галын аюулгүй ажиллагааны талаарх үзүүлэн сургалттай танилцаж, биечлэн хийх чадваруудаас суралцсан.

5. Компанийн ажилтнуудын мэргэжил, ур чадварын судалгааг гаргаж, түүнд тулгуурлан хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын түйцэтгэлийг сайжруулж, чанаржуулах зорилгоор сургалтын төлөвлөгөөг баталж төлөвлөгөөний дагуу ажилтнуудыг мэргэшүүлэх болон шаардлагатай сургалтанд хамруулах ажлыг хэрэгжүүлж хяналт тавьж ажилласан.

6. Эрхэлж буй ажлын онцлогтой уялдуулан компанийн ажилтнуудыг чанар, стандартын шаардлага хангасан өвөл, зуны ажлын хувцас, хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.

Тайлант хугацаанд Техник импорт ХК нь холбогдох хууль, журмаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр ирүүлсэн "Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай" 9/78 тоот албан бичиг, Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр ирүүлсэн "Хамтран ажиллах тухай" 01/39 тоот албан бичгээр өгсөн зөвлөмж, арга хэмжээг авч хэрэгжүүлж ажилллан компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам, Үнэт цаасны бүртгэлийн журамд заасан тавигдах шаардлагуудыг хангуулж компанийн засаглалтай холбоотой дараах хугацаат тайлан, мэдээг Хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж ажилласан. Үүнд:

1. Техник импорт ХК-ийн 2023 оны Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ын шийдвэр, тогтоол

- талаар ТУЗ-ын гаргасан шийдвэр, тогтоол
3. Техник импорт ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гаргасан шийдвэр, тогтоол, холбогдох баримт материалууд
 4. Хороонд бүртгэлтэй аудитын компаниар баталгаажуулсан Техник импорт ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын компанийн дүгнэлт
 5. Техник импорт ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан
 6. Техник импорт ХК-ийн 2024 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан
 7. Техник импорт ХК-ийн 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлан
 8. Техник импорт ХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Компанийн Дотоод аудитын алба

2012 онд компанийн удирдлагаас компанийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулж Гүйцэтгэх захирлын шууд удирдлаган дор ажиллах 2 хүний бүрэлдэхүүнтэй “Дотоод аудитын алба”-ыг анх байгуулсан. Энэхүү алба нь Гүйцэтгэх захирлаас өгсөн чиг үүргийн дагуу болон холбогдох дүрэм, журмаар олгосон чиг үүргийн хүрээнд компанийн үйл ажиллагаанд аудит хийж ТУЗ болон ТУЗ-ын Аудитын хороо, Гүйцэтгэх удирдлагаас тогтоосон хугацаанд аудитын ажлын тайлан, түүний үр дүнг тайлагнаж ажилладаг.

Тайлант хугацаанд компанийн Дотоод аудитын алба нь 2 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан.

2022 оноос эхлэн компани нь үйл ажиллагаандаа “Олон улсын чанарын менежментийн тогтолцоо”-г хэрэгжүүлж ажилласан ба MNS/ISO9001:2015 стандартын шаардлагыг хангах ажлын хүрээнд Гүйцэтгэх захирал 2022 оны 03 сарын 10-ны өдрийн A-08 тоот тушаалаараа “Санхүүгийн дотоод аудитын журам”, “Чанарын дотоод аудитын журам”-ыг шинээр баталж компанийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.

“Санхүүгийн дотоод аудитын журам”-ын дагуу компанийн үйл ажиллагаанд хийх “Санхүүгийн дотоод аудитын зорилго” нь толгой компани болон салбар, охин компаниудын санхүүгийн үйл ажиллагаа, үйлдвэрлэсэн болон борлуулж байгаа бараа бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил үйлчилгээ нь МУ-ын хууль тогтоомж, Гүйцэтгэх захирлын болон өөрийн гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хуулийн дагуу эредлээс урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг бол “Чанарын дотоод аудитын зорилго” нь Техник импорт ХК-ийн үйл ажиллагаа нь ISO 9001 стандартын дагуух чанарын менежментийн тогтолцооны шаардлагад нийцэж буй эсэх, хэрхэн үр нөлөөтэй хэрэгжиж байгааг тогтоох, нийлүүлэгчийг сонгох, захиалга хийх, бараа материал хүлээн авах, тээвэрлэх, хадгалах, борлуулалтын бүхий л шатанд чанартай үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах, тэдгээрийн гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн үйл явц, үүрэг хариуцлагыг тогтооход чиглэгддэг.

Тайлант хугацаанд Гүйцэтгэх захирлын тушаалын дагуу байгуулагдсан 6 гишүүнтэй Чанарын баг компанийн хэмжээнд чанарын дотоод аудитыг төлөвлөгөөний дагуу явуулж, үнэлгээ өгч ажилласан. Энэхүү ажиллагаагаар удирдлагын тогтолцооны хэрэгжилт үр дүнгээ өгч компанийн бичиг баримт цэгцэрч, чанарын менежментийн тогтолцооны хүрээнд удирдлага, менежерүүд болон ажилтнуудын үүрэг, хариуцлага тодорхой болж, ажлын үр дүнгийн бүртгэлүүдийн хөтлөлт хэвшиж ажилтан бүр өөрийн үйл ажиллагаандаа байнгын хяналт тавьж хэвшсэн ба дотоод аудитыг тодорхой давтамжтайгаар явуулах болсноор дүн шинжилгээ хийх, төлөвлөх, сайжруулах боломжийг бодитой болгосон.

Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл

Тайлант хугацаанд “Эрсдлийг тодорхойлох, сэргийлэх арга хэмжээг төлөвлөх журам” гаргаж энэхүү журмаар компанийн чиг үүргийн нэгж алба бүр үйл ажиллагааны явцад бүтсэглэхүүн.

ажилласан ба эрдлийг Гадаад орчноос хамаарах, Дотоод үйл ажиллагааны гэж 2 ангилик дотор нь дэд бүлгүүдээр нарийвчлан гаргаж тодорхойлсон. Энэхүү ажиллагаагаар нийтдээ компанийн хэмжээнд бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт учирч болзошгүй 77 эрдэл байгааг тодорхойлон гаргаж үнэлэн, тэдгээрийн шалтгааныг тогтоож, сэргийлэх арга хэмжээг нэгж алба бүр үйл ажиллагаандaa мөрдөж ажиллаж байна.

Эрдэлийг илрүүлж гаргах, үнэлэх, шалтгааныг тогтоох өдөр тутмын гүйцэтгэлийн хяналт, дотоод болон гадаад аудит, Харилцагч, хэрэглэгчийн санал гомдолд үндэслэн явуулж байгаа гэж үзэж болно.

Эрдлээс сэргийлэх арга хэмжээг ажлын гүйцэтгэлтэй уялдуулах талаар Чанарын багийн гишүүд, нэгж албадын дарга нар, менежерүүдэд сургалтаар танилцуулж, өдөр тутмын ажлын зааварчилгаа ёгч, эрдлээс сэргийлэх төлөвлөгөөг ажлын байр тус бүрт байршуулж, ашиглах боломжоор хангасан.

Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/

2024 оны 03 дугаар сарын 18-ны өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иас ирүүлсэн судалгаагаар: Нийт хувьцааны тоо: 1, 446, 755

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 461

№	Овог нэр	Хувьцааны төрөл	Эзэмшиж буй хувьцааны тоо /ширхэг/	Эзэмшиж буй хувь
1.	Д.Ганбат	Энгийн	475161	32,84%
2.	Д.Ганцэцэг	Энгийн	455736	31,5%
3.	Г.Содбилэг	Энгийн	480300	33,2%

Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл

Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлээгүй тул татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй.

Ногдол ашгийн мэдээлэл

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл жил бүр холбогдох хууль, журамд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ногдол ашгийн талаарх ТУЗ-ын тогтоол, шийдвэр, ногдол ашгийн тайланг танилцуулж тайлагнадаг.

Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны нэгж хувьцаанд ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хурлаараа хэлэлцэж шийдвэрлэсэн. Төлөөлөн удирдах зөвлөл ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ын тогтоол, шийдвэрийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу СЗХ, Хөрөнгийн бирж ХК-д хүргүүлж тайлагнаж ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөл 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 2023 оны нэгж хувьцаанд 1000 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн шийдвэрээ танилцуулж Хувьцаа эзэмшигчдээр хэлэлцүүлж батлуулсан.

2023 оны ногдол ашиг олгох талаар 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гаргасан тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр компанийн удирдлагаас дараах ажлыг зохион байгуулж ажилласан. Учил:

1. Компанийн нийт 1 446 755 ширхэг хувьцаанд 1 446 755 000 төгрөгийн ногдол ашиг олгохоос Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолыг үндэслэн 2024 оны 04 дүгээр сарын 16-ний өдөр компанийн 10 хувьцаа эзэмшигч ногдол ашгаа авах талаар гаргасан өргөдөл, хүсэлтийг үндэслэн 1 433 736 ширхэг хувьцаанд ногдох 1 433 736 000 төгрөгийн ногдол ашгийг компани дээрээс олгосон.
2. Санхүүгийн зохицуулах хорооноос 2024 оны 02-р сарын 27-ны өдөр ирүүлсэн “Тогтоолын хэрэгжилт хангуулах тухай” 3/712 тоот албан бичгээр өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан. Үүнд:

Техник импорт ХК-ийн удирдлагаас “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-тай 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр байгуулсан 03/24 тоот “ҮЦТХТ ХХК-иар зуучлуулан ногдол ашиг тараалгах гэрээ”-ний дагуу 2023 оны ногдол ашиг болох компанийн нийт 451 хувьцаа эзэмшигчийн 13 019 ширхэг нэгж хувьцаанд ногдох 12 356 800 төгрөгийг ҮЦТХТ ХХК-ийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв банк дахь 0099 0000 0006 тоот дансанд 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр шилжүүлж байршуулсан.

МУ-ын Компанийн тухай хууль болон холбогдох дүрэм, журам, эрх бүхий байгууллагаас ирүүлсэн албан бичигт заасан хугацаанд 2023 оны ногдол ашгийн тайланг холбогдох нотлох баримтын хамт СЗХ болон МХБ ХК-д тус тус хүргүүлж тайлagnаж ажилласан.

Тайлант хугацаанд Техник импорт ХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн “Даалгавар өгөх тухай” албан бичиг, Монголын хөрөнгийн бирж ХК-иас ирүүлсэн “Хамтран ажиллах тухай” албан бичиг болон албан бичгийн хавсралтад заасан хугацаанд компанийн дараах мэдээллийг СЗХ, МХБ ХК-д хүргүүлж тайлagnаж ажилласан. Үүнд:

1. Техник импорт ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан
2. Техник импорт ХК-ийн 2023 оны ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ын шийдвэр, тогтоол
3. Техник импорт ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах талаар ТУЗ-аас гаргасан шийдвэр, тогтоол, холбогдох баримт материалын хамт
4. Техник импорт ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл, тогтоол, холбогдох баримт материалын хамт
5. Техник импорт ХК-ийн 2023 оны санхүүгийн жилийн эцсийн тайланд хийсэн аудитын компанийн дүгнэлт,
6. 2023 оны ногдол ашгийн тайлан
7. Техник импорт ХК-ийн 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлан
8. Техник импорт ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан
9. Техник импорт ХК-ийн 2024 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан
10. 2 удаагийн Техник импорт ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийн үнэлгээний тайлан, холбогдох материалын тайлан, холбогдох материалын тайлан
11. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасныг үндэслэн тухай бүр мэдээлэх үүргийн дагуу ТУЗ-ын хурлын тогтоол, холбогдох материалын тайлан

Тайлант хугацааны ажлын үр дүн, үзэлгээ:

1. Тайлант хугацаанд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй 169 ХК-ийн “2024 оны жилийн эцсийн байдлаарх хууль, журам болон гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн судалгаа”-гаар Техник импорт ХК нь 100 оноотой дүгнэгдсэн.
2. 2024 оны эхний хагас жилд Санхүүгийн зохицуулах хороо Хөрөнгийн биржид бүртгэлтэй 108

тэргүүлэгч Топ-20 компани”-ийн нэгээр шалгарч үнэлэгдсэн.

3. Техник импорт ХК нь “Компанийн засаглалын кодексын хэрэгжилт”-ийн 2024 оны жилийн эцсийн үнэлгээгээр Монголын хөрөнгийн бирж ХК-д бүртгэлтэй 111 ХК-иас 5-р байранд орж үнэлэгдсэн.

4. Тайлант хугацаанд Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах ажлыг зохион байгуулж хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажилласан. Тус ХЭХ-ын материалыг холбогдох хууль, журамд заасан хугацааны дотор СЗХ, МХБ ХК-д хүргүүлж тайлагнасан. Мөн МХБ ХК-ийн цахим хуудсаар дамжуулан компанийн ХЭХ-аас гаргасан тогтоол, шийдвэрүүдийг мэдээлж олон нийтэд мэдээлэх үүргээ биелүүлж ажилласан.

Санхүүгийн зохицуулах хороо 2024 оны 05-р сарын 07-ны өдрийн 3/1642 тоот албан бичгээрээ “Техник импорт ХК нь ХЭХ-ыг зарлан хуралдуулахдаа Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн зар хүргэх журамд тус тус заасан журмын дагуу хуралдуулсан байна” гэсэн хариу ирүүлсэн.

Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл

Тайлант хугацаанд компаниас нийгмийн хариуцлагын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж хэрэгжүүлсэн болно. Үүнд:

1. “Ахмадын өдөр”-оөр компанийн ахмад ажилтнуудыг хүлээн авч уулзалт зохион байгуулах, бэлэг, дурсгалын зүйл гардуулахад зориулж 8,750,000 төгрөг,
2. Компанийн нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад зориулж 74 ажилтны эрүүл мэндийн үзлэгт 26 872 000 төгрөг,
3. Компанийн ажилтнуудыг ажлын хувцсаар хангахад зориулж 6 921 540 төгрөг,
4. Компанийн ажилтнуудыг эрүүл агаарт гаргах, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулж 57 ажилтан хамрагдсан зуны зугаалганд 16 918 309 төгрөг,
5. Компанийн 3 ажилтны орон сууцны урьдчилгаа төлбөрт 120 000 000 төгрөг,
6. Компанийн 4 ажилтны 4 хүүхдийг “Оюутны тэтгэлэг”-т хамруулж оюутны тэтгэлэгт зориулж 9 000 000 төгрөг,
7. Компанийн ажилтнуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, спортоор хичээллэх, ажлын бус цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд зориулж спорт заалны төлбөрт 3 600 000 төгрөг,
8. Компанийн ажилтнуудын хоолны зардалд 126 354 836 төгрөг,
9. Компанийн 114 ажилтан оролцсон “Шинэ жил”-ийн баярын үйл

10. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр компанийн ажилтнуудын 150 хүүхдэд “Хүүхдийн баярын бэлэг” өгөхөд зориулж 8 746 500 төгрөг, мөн харьяа Баянгол дүүргийн 28-р хорооны 20 хүүхдийн бэлгэнд 312 600 төгрөг,
11. Шинэ байранд орох, хүүхдийн сэвлэг үргээх, компанийн “Шилдэг ажилтан”-аар шалгарч гадаадад аялах болон гүйлтийн марафон тэмцээнд оролцсон, нас барсан ажилтны гэр бүлд тус тус буцалтгүй тусламж үзүүлэхэд зориулж 35 661 675 төгрөг

Овог, нэр: Д.Ганцээн

Албан тушаал: "Техник импорт" ХК-ийн

Гүйцэтгэх захирал



Овог, нэр:

Албан тушаал: "..... ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2025.04.30

Овог, нэр: О.Бүжинлхам

Албан тушаал: ТУЗ-ын нарийн бичгийн дарга

Гарын үсэг:
O. Бүжинлхам